



## НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг бэйгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4 дэх заалт, "Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дүрэм"-ийн 3.8, Хөдөлмөрийн дотоод журмын 3.1.1, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байдлын танилцуулга, мэдээлэл, санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Г.Гантүшиг	Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Ганзориг	Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
	Д.Баясгалан	Хүний нөөц, гэрээ, эрхзүй хариуцсан ахлах мэргэжилтэн
	Т. Аззаяа	Сургалт, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Х.Нямбаяр	Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Д.Эрдэнэбилэг	Стратеги төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байдлын өнөөгийн байдал, дунд хугацааны чиг хандлагын талаарх мэдээлэл, тулгамдаад байгаа асуудлууд, шийдвэрлэх арга замууд, цаашид хийж хэрэгжүүлж болохуйц ажлуудын саналыг боловсруулан, үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр танилцуулахыг Ажлын хэсэг /Г.Гантүшиг/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн хэлтэс /Г.Гантүшиг/-т даалгасугай.

ДАРГА

С.НЯМДОРЖ



1150600018